



МОНГОЛ УЛС  
ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН  
ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2023 оны 12 сарын 18 өдөр

Дугаар М/669

Есөнбулаг

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 60.1.21 дэх заалт, 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2020 оны 10 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийн 2.1.1 дэх зорилтыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд "Алтайн Мөнгөн шөнө" шинэ жилийн арга хэмжээг 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдөр аймгийн төв талбайд зохион байгуулсугай.

2. Арга хэмжээг зохион байгуулах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Дарга:	Ш.Эрдэнэбат	(Аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга)
Дэд дарга:	С.Цагаанбаатар	(Соёл, урлагийн газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч)
Гишүүд:	С.Мөнхжаргал	(Аймгийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтсийн дарга)
	Я.Жаргалцэцэг	(Аймгийн Засаг даргын Тамгын газрын Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн дарга)
	Х.Баатарзориг	(Аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү төрийн сангийн хэлтсийн дарга)
	Л.Хаш-Эрдэнэ	(Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга)
	Э.Пүрэвжав	(Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хяналт- Шинжилгээ, үнэлгээний хэлтсийн дарга)
	Д.Төмөрбаатар	(Аймгийн Засаг даргын Тамгын газрын цэргийн штабын дарга)
	А.Алтанхуяг	(Есөнбулаг сумын Засаг дарга)
	Б.Энхбаяр	(Зэвсэгт хүчний 341 дүгээр ангийн захирагч, Хурандаа)
	Н.Мэндбаяр	(Цагдаагийн газрын дарга)
	Ц.Лувсанжамц	(Онцгой байдлын газрын дарга)
	Г.Лхагважаргал	(Эрүүл мэндийн газрын дарга)
	Д.Баттайван	(Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын дарга)

Ж.Уранчимэг	(Биеийн тамир, спортын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч)
Б.Алтайбаатар	(Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын дарга)
Ж.Амгаланбаатар	(Боловсрол, шинжлэх ухааны газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч)
Г.Болдбаатар	(Байгаль, орчин аялал жуулчлалын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч)
Т.Сүхбаатар	(Хүнс, хөдөө аж ахуйн газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч)
Л.Ганхуяг	(Орон нутгийн өмчийн газрын дарга)
Д.Тунгалаг	(Статистикийн хэлтсийн дарга)
Н.Энхтуяа	(Татварын хэлтсийн дарга)
Г.Чүлтэмжамц	(Улсын бүртгэлийн хэлтсийн дарга)
Э.Отгонбаатар	(Ардын дуу бүжгийн "Алтай" чуулгын дарга)
Т.Эрхэмбаяр	("Инноваци судалгаа, бизнес хөгжлийн төв" УТҮГ-ын захирал)
М.Зандраа	("Нийтлэг үйлчилгээ" УТҮГ-ын менежер)
С.Алтайбаатар	(Аймгийн Нийтийн номын сангийн захирал)
Ш.Насан	(Аймгийн орон нутгийг судлах музейн захирал)
Х.Ундармаа	(Насан туршийн боловсролын төвийн захирал)
	Аймгийн Засаг даргын Тамгын газрын гэрээт хэвлэл мэдээллийн байгууллагууд
Нарийн бичгийн дарга:Т.Баярзул	(Аймгийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтсийн мэргэжилтэн)
Ц.Баасанжав	(Соёл, урлагийн газрын соёл, урлагийн хэлтсийн ахлах мэргэжилтэн)

3.Тус ажлыг зохион байгуулах бэлтгэл ажлын төлөвлөгөөг нарийвчлан гаргаж, шаардлагатай хөрөнгийн эх үүсвэрийг шийдвэрлүүлэн, үр дүнтэй удирдан зохион байгуулахыг ажлын хэсэг (С.Цагаанбаатар)-т үүрэг болгосугай.

4.Шинэ жилийн баярын өдрүүдэд нийгмийн хэв журам сахиулах, хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх, аюулгүй байдлыг хангах ажлыг зохион байгуулан хэрэгжүүлж ажиллахыг Цагдаагийн газар (Н.Мэндбаяр)-т үүрэг болгосугай.

5.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хяналт, шинжилгээ үнэлгээний хэлтэс (Э.Пүрэвжав)-т даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



О.АМГАЛАНБААТАР